



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 4/95

Мөрөн сум

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.4, 37.1.5, 37.1.8, 37.1.12, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ** нь:


1. Аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламж, төсөл арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх, чанарын асуудлыг сайжруулах, үр дүнтэй байлгах зорилгоор барилга захиалагчийн хяналт тавих этгээдтэй захиалагчийн хяналтын гэрээ заавал байгуулан гэрээний хуулбарыг тухайн төслийн гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргахыг агентлаг, байгууллагын удирдлагууд, сумын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

2. Агентлаг, байгууллагын удирдлагууд, сумын Засаг дарга наартай барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын гэрээг Барилгын тухай хууль, Барилгын ажлын захиалагчийн дүрэм бусад хууль тогтоомжийн хүрээнд байгуулж ажиллахыг “Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв” ОНӨААТҮГ (Х.Даваасүрэн)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) наарт тус тус даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж 2024

6712010302